

**МОНГОЛ УЛС: АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ГАДААД ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН**

**Цогтсайханы Болормаа**, доктор (Ph.D), МУИС-ШУС-ийн Эдийн засгийн тэнхим, Хүн ам зүйн профессор

**Хураангуй**

Энэхүү судалгааны ажлаараа Монгол Улсын гадаад шилжилт хөдөлгөөний талаар, тухайлбал, Монгол Улсад ажиллаж, амьдарч буй гадаадын иргэд болоод Монгол Улсаас гадаадын улс орнуудад ажиллаж, амьдарч буй монгол иргэдийн тоо хэмжээ, нөхцөл байдлын талаар авч үзлээ. Албан ёсны статистик мэдээллээр, гадаадад монголын 100 мянга гаруй иргэн, монголд гадаадын 35 мянга гаруй иргэд байна. Монгол Улсад 35 мянга гаруй иргэд ажиллаж, амьдарч байгаа ч тэдний зөвхөн 20 орчим хувь нь хөдөлмөр идэвхтэй эрхэлж байна. Сүүлийн жилүүдэд хөдөлмөр идэвхтэй эрхэлж буй гадаад иргэдийн тоо буурч байна. Хөдөлмөр эрхэлж буй иргэдийн 50 гаруй хувийг БНХАУ-ын иргэд эзэлж, тэдний дийлэнх нь уул уурхай, олборлолт, барилгын салбарт ажиллаж байна.

Монгол Улсаас гадаадад ажиллаж амьдарч буй нийт 100 мянга гаруй иргэн байна. Тэдний гуравны нэг нь БНСУ-д ажиллаж, амьдарч байна. Сүүлийн жилүүдэд тус улсад ажиллаж, амьдарч буй монгол иргэдийн тоо нэмэгдэж байна. Гэхдээ хөдөлмөр эрхлэх зорилготой, хөдөлмөрийн гэрээт ажилчдын тоо эрс буурсан байна. Гэрээт ажилчдын хувьд ажил олгогчийн зүгээс хууль зөрчиж, гэрээгээ зөрчих байдал байна. Тухайлбал, ажил олгогчийн зүгээс гэрээ зөрчих шалтгаанд, цалин, ажлын болон амралтын цаг, өдрийн цагийн төлбөр, байр сууц, хоолны төлбөр, ажлын байрны байршил зэрэгтэй холбоотой шалтгаанууд орж байна. Мөн БНСУ-д ажиллаж буй монгол иргэдийг ажил олгогч болоод бусад солонгос ажилчдын зүгээс дарамт шахалт (хэл амаар доромжлох, паспорт бичиг баримтыг хураан авах гэх мэт) үзүүлэх байдал байсаар байна. Монгол Улсын ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөний талаарх тоо мэдээлэл хангалтгүй, албан ёсны мэдээллийн тогтолцоо бий болгох зайлшгүй хэрэгтэй байна. Энэ талын тоо мэдээлэл гаргаж буй эх үүсвэр хоорондын мэдээлэл зөрүүтэй байна. Мөн гадаад шилжилт хөдөлгөөний зорилго, үр дагавар, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг албан ёсоор цуглуулдаг болох хэрэгтэй байна.

**Түлхүүр үгс:** Гадаад шилжилт хөдөлгөөн, ажиллах хүчний шилжилт, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал

**Abstract**

This study examines the stock and conditions of Mongolian labor migration including, foreigners living in Mongolia and Mongolian citizens living and working abroad. According to official statistics, over 100 thousand Mongolians live and work abroad and over 35 thousand foreigners in Mongolia. Over 35,000 foreigners work and live in Mongolia, only about 20 percent of them work actively. In recent years, the number of active working labor migrants is declining. More than 50 percent of the active employed people are Chinese, and most of them are engaged in the mining and construction sectors.

There are over 100,000 Mongolia people living and working abroad and the one-third of them work in Korea. In recent years, the number of Mongolians living and working in Korea has increased. However, the number of contracted workers has declined dramatically. The Korean employers violate the law and work contracts. For instance, the infringement includes wages, working hours, rest time, day of payment, lodging, meal pay, and work place location. The Mongolian workers in Korea have been experienced ill treatment (verbal abuse and abusive language, confiscation of passport etc.) from Korean colleagues or employer. There is insufficient data on the Mongolian labor migration statistics and the information between the data sources is so different. It is also important to collect more detailed information on the reasons and consequences of labor migration and employment conditions. Therefore, it is necessary to establish a formal information system regarding international migration of Mongolia urgently.

**Key words:** International migration, labor migration, working conditions

## 1. УДИРТГАЛ

Дэлхий нийтийн хандлагаас харахад, сүүлийн жилүүдэд гадаад шилжих хөдөлгөөн эрс нэмэгдэж, 258 сая хүн гадаад шилжигч хэмээн бүртгэгдээд байна. Хөгжингүй орнуудын дийлэнх нь хүлээн авагч, харин хөгжиж буй орнууд, ялангуяа, Зүүн өмнөд Азийн орнууд илгээгч оронд орж байна. Гадаадад ажиллах хүч илгээгч улсын хувьд Зүүн өмнөд Азийн улсууд хамгийн их хувь эзэлж байна. Тухайлбал, жил бүр ойролцоогоор 2 сая Ази ажилчид гадаад улсад ажиллахаар явдаг бөгөөд Филиппин, Индонези, Тай, Бирм, Вьетнам үндэстнүүд даруй 60 хувийг эзэлдэг ажээ. Хүлээн авагч улсын хувьд, эхний аравт АНУ, ОХУ, ХБНГУ, Саудын Араб, Канад, ИБНВУ, Испани, Франц, Австрали, Энэтхэг улсууд ордог ч Азийн орнууд дотроо хамгийн их ажиллах хүч хүлээн авагч оронд Сингапур, БНСУ орж байна.

Өнөө цаг үед олон мянган хүмүүс гэр бүл, үр хүүхдийнхээ сайн сайхан аж байдал, аюулгүй амьралын төлөө өөрийн төрсөн газар нутгаа орхин нэг улсаас нөгөө улс руу, нэг бүсээс нөгөө бүсэд шилжин суурьшсаар байна. Шилжилт хөдөлгөөнд оролцогчдын дийлэнх нь өндөр цалин хөлс, амьдралын илүү сайн боломжийн төлөө явж байгаа бол зарим хэсэг нь өлсгөлөн, ядуурал, байгалийн гамшиг, хүрээлэн буй орчны тэнцвэрт бус байдал, хүчирхийлэл, дотоодын зөрчил, мөргөлдөөн зэрэг өөрөөс үл хамаарах шалтгааны улмаас шилжилтэд оролцож байна. Ерөнхийдөө, улс орнуудын хувьд хөдөлмөр эрхлэх боломж, зохистой ажлын байр, хүний аюулгүй байдал, хувь хүний эрх чөлөө зэрэг олон асуудал хоорондын ялгавартай байдал жилээс жилд нэмэгдэж байгаа нь шилжилт хөдөлгөөнд оролцогчдын сонирхолыг улам бүр өдөөж байна. Гадаад шилжилт хөдөлгөөнд оролцсоноор зарим хүмүүс илүү боломж, бололцоотой болж, амьжиргааны түвшин, аж байдлаа сайжруулж, үр өгөөж хүртэж чадаж байгаа ч гадаадын улс орнуудад ажиллагч дийлэнх шилжигчдийн хувьд ажлын нөхцөл байдал хүнд, амьдралын тав тухтай орчингоор төдийлэн хангагдаж чадахгүй байна. Ийм учраас ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөн нь тухайн улс орны эдийн засаг, нийгмийн бодлогын нэгэн гол салшгүй хэсэг болж, бодлогоор зохицуулах гарцаагүй

хэрэгцээ шаардлага гарсаар байна. Ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөний бодлогын олон янзын арга хэмжээ, туршлагыг улс орнууд туршиж, нэвтрүүлж, хэрэглэж байгаа ч төдийлөн амжилтад хүрч чадахгүй байна. Гэсэн хэдий ч улс орнуудын төр засаг шилжилт хөдөлгөөний асуудал хариуцсан олон улсын байгууллагууд, тухайлбал, Олон улсын шилжих хөдөлгөөний (ОУШХБ) болон Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-тай хамтран, ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөний шалтгаан, тэдгээрт тулгамдаад байгаа сорил, үр дагаврыг шийдэхийг эрэлхийлж байна.

Монгол Улсын хувьд гадаадад ажиллаж, амьдарч байгаа монголчуудын нөхцөл байдал, тэдний нийгэм, эдийн засаг, өрх гэр бүлд үзүүлж буй үр дагаврын талаарх томоохон түүвэр судалгааг 2005 онд Монголын хүн ам, хөгжил нийгэмлэг, 2016 онд Хүний хөгжил судалгаа, сургалтын төв тус тус хийсэн. Үүнээс гадна, Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-оос Хүн ам, орон сууцны 2010 оны үндсэн тооллого, 2015 оны завсрын тооллогын хүрээнд гадаадад ажиллаж, амьдарч байгаа монголчуудын болон гадаадын улс орнуудаас монголд ажиллаж, амьдарч байгаа иргэдийн тухай ерөнхий мэдээллийг цуглуулсан. Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ)-аас хөдөлмөрийн зах зээл, нийгмийн халамжийн үйлчилгээний төлөв байдлын тухай танилцуулгын хүрээнд “Гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал” нэрийн дор Монгол Улсад ажиллаж, амьдарч буй гадаад иргэдийн талаарх мэдээллийг жил бүр (2010 оноос хойш) тогтмол танилцуулж байна. Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт (ХНХСИ)-ээс 2016 онд “Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийн нөхцөл байдлын судалгаа”, “Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний нөхцөл байдлын судалгаа”, “БНСУ, Япон улсад хөдөлмөр эрхэлж буй болон эх орондоо эргэн ирсэн иргэдийн нөхцөл байдлын судалгаа”, “Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний өнөөгийн нөхцөл байдалд хийсэн баримт бичгийн шинжилгээ” зэрэг байгууллагын дотоод хэрэгцээнд зориулсан 4 судалгаа, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо (МХЭХ)-оос “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах

<sup>1</sup> UNs, Department of Economic and Social Affairs, International Migration Policies Data Booklet, 2018.

тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээ"-г 2015 онд хийжээ. Тэгэхээр Монгол Улсын болоод Монгол Улс дах ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөний талаарх албан ёсны тоо мэдээлэл дээр дурьдсан эх үүсвэрээс өөр алга байна. Эдгээр судалгааны мэдээлэл нь ихэвчлэн албан хэрэгцээнд зориулагдсанаас иргэд, олон нийтэд тэр бүр хүрч чадаагүй байна. Гадаад шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тоо мэдээллийн талаар иргэд, олон нийт зөвхөн албан бус эх үүсвэрээс авсан мэдээ, мэдээллийг хоорондоо солилцох, ярилцах явдал өнөөгийн нийгэмд түгээмэл байна. Иймд судлаачийн хувьд дээр дурьдсан тооллого, судалгаа шинжилгээний материалуудад дүн шинжилгээ хийн, Монгол Улсаас гадаадын улс орнуудад ажиллаж амьдарч байгаа болон Монгол Улсад ажиллаж амьдарч буй гадаад иргэдийн талаарх нэгдсэн бодит мэдээллийг хүргэх зорилгоор энэхүү ажлаа толилуульж байна.


## 2. МОНГОЛ УЛС ДАХ ГАДААД ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Гадаадын улс орнуудаас Монгол Улсад ажиллаж, амьдарч байгаа гадаад иргэдийн тоог албан ёсоор ҮСХ-оос хийсэн 2010 оны Хүн ам, орон сууцны тооллогоор гаргасан байдаг<sup>2</sup>. Тооллогын дүнгээс харахад, гадаадын улс орнуудын 16 мянга (Монгол Улсын нийт хүн амын 0.6 хувьтай тэнцэх) орчим хүн байгаагийн 50 гаруй хувь нь БНХАУ-ын иргэд, үлдсэн хэсэг нь ОХУ, БНСУ, АНУ болон бусад улс орны иргэд байна. Насны бүлгийн хувьд, 20-49 насны, дийлэнх олонх (бараг 80 орчим хувь) нь эрэгтэйчүүд байна. Гадаадын харъяат иргэн хамгийн олноор оршин сууж буй газар нутагт Улаанбаатар хот, Өмнөговь, Орхон, Сэлэнгэ, Дорноговь зэрэг аймаг орж байгаа ба Монгол Улсад амьдарч байгаа нийт гадаадын харъяат иргэдийн 90 орчим хувь нь эдгээр бүс нутагт ажиллаж, амьдарч байна.

Монгол Улсад ажиллаж, амьдарч буй гадаад иргэдийн талаарх тоо мэдээлэл хангалтгүй байдаг тул Гадаадын иргэн, харъяатын газар (ГИХГ)-т бүртгэлтэй гадаадын иргэд болон ХХҮЕГ-аас хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үйлчилгээ авсан гадаад иргэдийн талаарх тоо мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тэдний

хөдөлмөр эрхлэлтийн талаар тодруулахыг оролдлоо.

ГИХГ-ын албан ёсны мэдээлэлд үндэслэн Монгол Улсад оршин сууж буй гадаадын иргэдийн талаарх мэдээллийг 2010-2016 оны байдлаар нэгтгэн Зураг 1-д харууллаа. Сүүлийн 7 жилийн байдлаас харахад, жилд дунджаар 32 мянга орчим гадаад иргэд монголд ажиллаж, амьдарч байна. Тэдний дийлэнх нь хөдөлмөр эрхлэх зорилгоор амьдардаг байна. Гэхдээ хөдөлмөр эрхлэх зорилгоор монголд амьдарч буй гадаад иргэдийн тоо сүүлийн 2 жилд эрчимтэй буурчээ. 2010-2014 онуудад нийт гадаад иргэдийн 80 гаруй хувь нь энэ зорилгоор монголд амьдарч байсан бол буурсаар 2015 онд 60 орчим хувь, 2016 онд бараг 50 хувьд хүрсэн байна. Энэ нь 2011-2014 онд барилга, уул уурхайн салбар эрчимтэй өсч, гадаад ажиллах хүч олноор орж ирсэн, харин 2015 оноос эдийн засгийн хямралт байдал эхэлж, гадаадын хөрөнгө оруулалт хумигдан, гадаадын шууд хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд ажиллах хүчнээ тодорхой түвшинд бууруулсантай холбоотой юм.



Удаан хугацаагаар монголд оршин сууж буй иргэдийн тоо жилд дунджаар 30 мянга орчимд хэлбэлзэж байгаа ч ХХҮЕГ-аас хөдөлмөр эрхлэхээр зөвшөөрөл авсан гадаад ажилчдын тоо нийт оршин сууж буй гадаад иргэдийн тооноос даруй 5-7 мянгаар, харин хөдөлмөр эрхлэх зорилгоор оршин сууж буй гадаад иргэдээс 3-5 мянгаар тус тус илүү байна (Хүснэгт 1).

<sup>2</sup> ҮСХ 2011. Хүн ам, орон сууцны тооллого 2010: Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэд.

**Хүснэгт 1. Монгол Улсад ажиллаж, амьдарч буй гадаад иргэдийн тоо, 2010-2016**

Он	Монгол Улсад оршин сууж буй гадаад иргэдийн тоо (ГИХГ-ын мэдээллээр)	Хөдөлмөр эрхлэх зорилгоор оршин сууж буй гадаад иргэдийн тоо (ГИХГ-ын мэдээллээр)	Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан гадаад иргэдийн тоо (ХХҮЕГ-ын мэдээллээр)	Хөдөлмөр идэвхтэй эрхэлж буй гадаад иргэдийн тоо (ХХҮЕГ-ын мэдээллээр)
2010	22187	13938	30566	9990
2011	34201	28195	27131	15494
2012	31179	26597	27195	10060
2013	31075	26686	27195	8863
2014	29766	24430	26104	7971
2015	38424	22558	16644	6770
2016	35027	16869	10523	5938

Эх үүсвэр: ХХҮЕГ, ГИХГ-ын 2010-2016 оны тоо мэдээллэлд үндэслэн судлаач өөрөө нэгтгэн тооцов.

Хэдийгээр хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан гадаад иргэдийн тоо олон ч Монгол Улсад оршин суугаад хөдөлмөр идэвхтэй эрхлэх байдал даруй хэд дахин бага байна. Тухайлбал, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан иргэдийн 50 гаруй хувь нь байнгын оршин сууж, хөдөлмөр идэвхтэй эрхэлж байна. Мөн хөдөлмөр эрхлэх зорилгоор удаан хугацаагаар оршин сууж буй иргэдийн тоо хөдөлмөр идэвхтэй эрхэлж буй иргэдийн тооноос бараг 2-3 дахин их байгаа нь сонирхол татаж байна. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зорилгоор удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл авч, орж ирсэн хойноо хөдөлмөр эрхлэхээр албан ёсоор зөвшөөрөл авсан болон хөдөлмөр идэвхтэй эрхэлж буй байдал

хооронд ихээхэн зөрүүтэй байдал ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, гадаад иргэдийн хувьд удаан хугацаагаар оршин суух зорилгоо бодитоор биелүүлэхгүй байна гэсэн үг.

Хүснэгт 2-оор хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үйлчилгээ авсан гадаад иргэдийн тоог, авсан үйлчилгээний төрлөөр харуулав. Уг мэдээллийг ХХҮЕГ-аас жил бүр гаргадаг. Хүснэгтээс харахад, уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байсан онуудад үйлчилгээ авсан гадаад иргэдийн тоо хэмжээ бараг 6 дахин их байснаа сүүлийн жилүүдийн эдийн засгийн хямралт байдалтай холбоотойгоор мөн хэмжээгээр багассан байдал ажиглагдаж байна.

**Хүснэгт 2: Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үйлчилгээ авсан гадаад иргэдийн тоо, үйлчилгээний төрлөөр, 2010-2017**

Үйлчилгээний төрөл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Нийт	68541	116539	115350	111109	114548	79447	53271	51890
Урилга	21420	36957	31673	30595	29929	20115	13601	12107
Зөвшөөрөл	18494	62476	64959	63079	24734	16643	11152	10503
Сунгалт	16221	-	-	-	27855	25861	17102	18780
Хасалт	12406	17106	18718	17435	16157	16828	11416	10500


Эх үүсвэр: ХХҮЕГ-ын 2010-2017 оны тоо мэдээллэлд үндэслэн судлаач өөрөө нэгтгэн гаргав.

Тайлбар: Оны эхнээс өссөн дүнгээр тооцоолон гаргав. 2011-2013 онд "сунгалт" хийгдсэн иргэдийн тоог "зөвшөөрөл" авсан иргэдэд оруулан тооцсон байв.

Хэдийгээр нэг жилийн хугацаанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан (Хүснэгт 1-ийг хар), мөн үйлчилгээ авсан гадаад иргэдийн тоо (Хүснэгт 2-ыг хар) өндөр мэт харагдаж байгаа ч тэдгээрээс идэвхтэй хөдөлмөр эрхэлж буй иргэдийн тоо харьцангуй цөөхөн байна. Хөдөлмөр байнга идэвхтэй эрхэлж буй гадаад иргэдийн талаарх тоо мэдээллийг Зураг 2-д харуулав. Хөдөлмөр идэвхтэй эрхэлж буй иргэдийн тоо 2011 онд буюу уул уурхайн салбарын эрчимтэй өсөлтийн дүнд манай

улсын эдийн засгийн өсөлт өндөр байсан онд хамгийн өндөр байжээ. Үүнээс хойш жил ирэх тутам гадаад ажиллагчдын тоо буурсаар даруй 4700 гаруй болсон байна.

Гадаад ажиллагчдын 80 гаруй хувь нь эрэгтэйчүүд байгаа ч сүүлийн жилүүдэд эмэгтэй ажиллагчдын хувийн жин жилээс жилд өсөн нэмэгдэх байдал ажиглагдаж байна.



Монголд хөдөлмөр идэвхтэй эрхэлж буй гадаадын иргэдийг улсаар ангилан харвал, 2010-2011 оны үед нийт гадаад ажиллагсдын 60 гаруй хувь нь БНХАУ-ын иргэд байсан бол 2017 он гэхэд 2 дахин буурчээ. Харин БНСУ, Австрали, Канад улсын иргэдийн хөдөлмөр эрхлэлт харьцангуй нэмэгдэж, БНАСАУ-аас ажиллаж буй иргэдийн тоо 2011-2013 онд эрчимтэй өсч байснаа 2017 онд тухайн үеийнхээс бараг 3 дахин буурсан байдал ажиглагдаж байна.

### Хүснэгт 3. Хөдөлмөр идэвхтэй эрхэлж буй гадаад иргэдийн хувийн жин, улсаар, 2010-2017

Улс	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Нийт тоо	9990	15494	10060	8863	7971	6779	5938	4703
БНХАУ	61.4	63.1	38.6	32.1	34.6	35.4	34.5	37.5
БНАСАУ	6.0	9.2	16.9	24.0	22.9	23.0	19.9	7.2
ОХУ	7.7	5.0	7.2	7.6	7.4	8.3	8.0	7.3
БНСУ	4.1	2.9	5.0	6.2	6.4	6.8	5.9	6.5
Австрали	1.7	2.2	4.0	3.2	2.7	2.5	-	7.1
АНУ	3.3	2.9	4.5	4.0	4.0	4.2	4.5	5.4
Канад	1.0	1.3	2.0	1.0	1.0	-	-	3.6
БНСВУ	1.9	2.4	4.6	6.2	5.7	3.4	2.5	4.2
Англи	-	0.8	1.5	1.4	1.1	-	-	2.5
Филиппин	1.7	1.9	2.1	1.7	1.4	1.7	-	2.0
Бусад	11.2	10.7	13.6	12.6	12.8	14.8	24.7	16.7

Эх үүсвэр: ХХҮЕГ, 2010-2017. Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал

Хөдөлмөр идэвхтэй эрхэлж буй гадаад иргэдийн гурван хүн тутмын нэг нь уул уурхай олборлолтын салбарт ажиллаж байна. Уул уурхайн салбарт ажиллаж буй гадаад иргэдийн хувь эрчимтэй нэмэгдэж 2017 он гэхэд нийт хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийн бараг 40 орчим хувийг эзэлдэг болжээ. Боловсролын салбарт хөдөлмөр

эрхэлж буй гадаад иргэдийн тоо мөн жилээс жилд эрчимтэй өсч, 2010 оны үеийнхээс даруй 2 дахин өссөн байна. Харин 2017 оны байдлаар барилгын салбарт ажиллагсдын хувь 2010-аад оны үетэй харьцуулахад бараг 2-3 дахин, тээвэр, агуулахын үйл ажиллагаа эрхлэгч гадаад иргэдийн тоо 7 дахин тус тус буурсан байна.

### Хүснэгт 4. Хөдөлмөр идэвхтэй эрхэлж буй гадаад иргэдийн хувийн жин, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2010-2017

Улс	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Нийт тоо	9990	15494	10060	8863	7971	6779	5938	4703
Барилга	5.9	33.9	21.0	26.3	21.6	27.9	16.3	7.7
Уул уурхай, олборлолт	30.4	15.6	19.0	16.3	20.4	21.4	33.1	37.3
Худалдаа үйлчилгээ	25.3	13.3	10.9	13.3	13.2	10.7	10.3	13.8
Боловсруулах үйлдвэр	9.7	6.9	10.7	11.2	14.0	13.6	13.0	7.2
Боловсрол	9.0	5.7	10.9	11.0	11.4	14.1	15.5	18.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	7.5	14.8	15.0	9.1	6.0	1.2	1.6	2.1
Бусад	12.2	9.8	12.5	12.8	13.4	11.1	10.2	13.1

Эх үүсвэр: ХХҮЕГ, 2010-2017. Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал

Сүүлийн 3 жилийн байдлаар (2015-2017) хөдөлмөр идэвхтэй эрхэлж буй гадаад иргэдийг байршлаар харвал, нийслэл Улаанбаатар хотод ажиллагч иргэд буурч, аймаг орон нутагт ажиллагч гадаад иргэдийн тоо өсөх хандлагатай байна. Тухайлбал, 2015 онд нийт гадаад ажиллагсдын 60 гаруй хувь нь Улаанбаатар ажиллаж, амьдарч байсан бол энэ үзүүлэлт буурсаар 2017 он гэхэд бараг 50 хувь хүрэхтэй үгүйтэй болжээ. Аймаг, орон нутагт ажиллагч гадаад иргэдийн дийлэнх нь Өмнөговь, Дорноговь, Орхон аймгуудад ажиллаж байна.

Монгол Улсад хөдөлмөр идэвхтэй эрхэлж буй гадаад иргэдийн цалин хөлсний талаарх мэдээлэл ихээхэн ховор, олдоц муу байна. Гэсэн хэдий ч БНХАУ-аас монголд ажиллаж буй иргэдийн цалингийн талаарх мэдээллийг олж, дүн шинжилгээ хийж үзлээ.

Монголд ажиллаж буй БНХАУ-ын иргэдийн хувьд цалин хөлсний дундаж түвшин эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ихээхэн ялгаатай байна. Тухайлбал, уул уурхай, олборлолт, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын чиглэлийн үйл ажиллагаа

эрхэлж буй хятад иргэдийн дундаж цалин бусад салбарт ажиллагсдынхаасаа бараг 2-3 дахин өндөр байна. Уул уурхайн салбарт ажиллагч хятад ажилчдын дундаж цалин 2.0 сая гаран төгрөг байгаа нь хамгийн өндөр, харин үйлчилгээний бусад үйл ажиллагаа эрхлэгч хятад иргэдийн цалин хөлс 200 гаруй мянган төгрөг байгаа нь хамгийн багад тооцогдож байна. Хятад иргэдийн цалин хөлсний дундаж хэмжээг монгол ажилчдын цалин хөлстэй харьцуулбал, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ихээхэн ялгаатай байна. ХАА-н чиглэлийн аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж буй хятад иргэдийн цалингийн дундаж хэмжээ монгол ажиллагчдын цалингийн дундаж хэмжээнээс харьцангуй өндөр байна. Харин бусад салбарын хувьд, ялангуяа, сүүлийн жилүүдэд монгол ажилчдын дундаж цалин хөлсний түвшин илүү өндөр байна. Хятад ажилчид олноороо ажилладаг салбар бол барилга, гэтэл тэдний авч буй цалин хөлсний хэмжээ монгол ажиллагчдын цалингийн дундажтай харьцуулахад ихээхэн бага буюу бараг 2 дахин бага байна.

**Хүснэгт 5. Хөдөлмөр идэвхтэй эрхэлж буй гадаад (БНХАУ-ын иргэн) болон монгол ажилчдын дундаж цалин, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, (мян.төг) 2010-2016**

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2010		2011		2012		2014		2015		2016	
	Гадаад	Монгол	Гадаад	Монгол	Гадаад	Монгол	Гадаад	Монгол	Гадаад	Монгол	Гадаад	Монгол
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	428.2	172.5	561.0	203.1	854.5	244.5	558.3	752.9	905.9	643.9	1064.6	631.5
Уул уурхай, олборлолт	1084.3	572.2	396.4	732.8	775.4	814.5	503.2	1550.8	401.3	1895.4	2052.9	1989.4
Боловсруулах үйлдвэр	567.7	326.2	708.8	402.8	622.3	498.5	485.8	765.2	900.8	770.1	791.2	887.0
Барилга	154.8	247.5	188.2	341.7	208.9	485.1	299.2	678.7	342.7	662.8	343.5	729.5
Бөөний, жижиглэн худалдаа, машин засвар үйлчилгээ	242.1	231.6	315.3	273.0	568.4	356.8	472.3	723.7	658.8	695.3	693.0	742.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	436.7	369.0	333.9	487.2	181.3	521.3	248.7	924.5	384.1	885.0	740.1	984.8
Боловсрол	407.3	311.6	558.4	366.1	464.3	529.4	517.1	705.2	478.3	735.5	535.4	712.9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	116.1	257.6	240.2	305.3	258.8	436.3	755.5	601.2	472.0	722.0	204.5	724.3

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, 2017. ҮСХ, 2017. [www.1212.mn](http://www.1212.mn)

Тайлбар: Гадаад иргэдийн цалин хөлсний мэдээлэл олдоц муу байсан тул энд БНХАУ-аас монголд ажиллаж буй хятад иргэдийн цалингийн дундаж мэдээллийг зөвхөн харуулав. "Гадаад" гэдэг нь БНХАУ-аас монголд хөдөлмөр идэвхтэй эрхэлж буй иргэд болно.

Эндээс харахад, гадаад ажиллах хүчний хувьд илүү хямд өртөг бүхий байгаа учраас монголын аж ахуйн нэгж байгууллагынхан гаднаас ажиллах хүч авах сонирхолтой байж

болох талтай харагдаж байна. Гэхдээ нөгөө талаас, ажил олгогч нар гадаад ажилчдыг ихэвчлэн хоол, унаа, орон байраар хангадаг учраас дундаж цалингийн түвшин харьцангуй

бага тогтоогддог байж магадгүй юм.

Монголын аж ахуйн нэгж байгууллагууд гадаадаас ажиллах хүч авах болсон шалтгааныг тодруулах үүднээс 10 ба түүнээс дээш гадаад ажилчидтай 50 аж ахуйн нэгжийг хамруулан хийсэн ХНХСИ-ийн судалгаанаас<sup>3</sup> зарим мэдээллийг авч үзлээ.

Судалгаанаас харахад, Монгол Улсын иргэний аж ахуйн нэгж байгууллагын хувьд, монгол ажиллагчид хувийн зохион байгуулалт болон ажилд хандах хандлага муу учраас гадаад ажиллах хүч авах сонирхолтой гэж дийлэнх нь үзэж байхад гадаад улсын иргэний буюу гадаад хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тухайд, ажлын байранд тохирсон ур чадвар бүхий монгол ажилтан олддоггүй, монгол ажилчид тогтвор суурьшилтай ажиллаж чаддаггүй, мөн гадаад хөрөнгө оруулалттай учраас гадаад ажиллах хүч авах ихээхэн сонирхолтой байдаг ажээ.

### **3. МОНГОЛ ИРГЭДИЙН ГАДААДЫН УЛС ОРНУУДАД ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БУЙ БАЙДАЛ**

Монгол Улсын хувьд 2015 оны байдлаар 100 мянга гаруй монгол иргэн гадаадад ажиллаж, амьдарч байна<sup>4</sup>. Гадаад шилжих хөдөлгөөнд оролцсон монгол иргэдийн гуравны нэг нь суралцах, гуравны нэг нь ажиллах, үлдсэн хувь нь бусад зорилгоор шилжин явагсад гэж үздэг. Зарим иргэд гадаадад хууль бусаар очсноор өөрсдийгөө эрсдэлд оруулж, хүний наймааны золиос болох, гэмт хэрэг үйлдэх тохиолдол багагүй тохиолддог байна<sup>5</sup>.

Гадаадад ажиллаж амьдарч байгаа монголчуудын бодит статистик тоо мэдээлэл нэлээд зөрүүтэй байна. Тухайлбал, Гадаад харилцааны яам (ГХЯ)-ны албан ёсны мэдээгээр, 2010 онд 134 мянга гаруй монгол иргэн гадаадад ажиллаж, амьдардаг гэсэн бол ҮСХ-оос явуулсан 2010 оны Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр, 107 мянга орчим иргэн гэжээ. Энэ тоо 2015 оны Хүн ам, орон сууцны завсрын тооллогын дүнгээр ч гэсэн мөн батлагдсан байна. Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс харахад, гадаад шилжилт хөдөлгөөнд оролцогчдын 40 орчим хувь хөдөлмөрлөх (буюу хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, хувиараа ажиллах, албан

томиллолтоор ажиллах), 37.0 хувь суралцах, 0.7 хувь эмчлүүлэх, үлдсэн 20 гаруй хувь бусад (гэр бүл, үр хүүхдээ дагах, гадаад улс оронд амьдрах сонирхол, амьдрах таатай орчин, гадаад улс орны соёл заншилтай танилцах гэх мэт) шалтгаан, зорилгын улмаас шилжилтэд оролцжээ. Монголчуудыг хүлээн авагч орны тоонд БНСУ, АНУ, БНЧУ, БНХАУ, Япон, ОХУ зэрэг орж байгаа бөгөөд эдгээр орнуудад 70 мянга гаруй монголчууд ажиллаж, амьдарч байна. БНСУ, АНУ, БНЧУ, Япон зэрэг улс орнуудад хөдөлмөр эрхлэх зорилгоор, тухайлбал, БНСУ, БНЧУ, Япон улс руу хөдөлмөрийн гэрээгээр ажиллах зорилгоор ихэвчлэн явж байгаа бол АНУ, БНХАУ, ОХУ руу суралцах зорилгоор явдаг байна.

Гадаадад ажиллаж, амьдарч байгаа монголчуудын талаарх хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн шинж байдлын үзүүлэлтээр дэлгэрэнгүй харуулсан статистик мэдээлэл ховор байна. Хүн ам, орон сууцны тооллого 2010 оны дүнгээр л гадаадад байгаа монголчуудын талаарх мэдээллийг нас, хүйс, гэрлэлтийн статус, гадаадад явсан зорилго, гадаадад амьдарч байгаа дундаж хугацаа, оршин суугаа улс орноор ангилсан мэдээлэл байна. Харин 2015 оны дунд хугацааны завсрын тооллогоор гадаадад ажиллаж, амьдарч байгаа зөвхөн нийт хүмүүсийн тоо (87.4 мянган хүн)-г гаргажээ.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр, гадаадад байгаа монголчуудын дийлэнх олонх нь 20-49 насны хөдөлмөрийн насны хүн ам байна (Хүснэгт 6). Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийн талаар хийгдсэн хоёр судалгааны дүн мөн дээр дурьдсан насны бүлгийн хандлагыг харуулсан байна. Тухайлбал, МХАХН-ээс 2005 онд хийсэн судалгаанд хамрагдсан гадаад ажиллаж буй монголчуудын дийлэнх нь 20-34 насны залуучууд байсан бол “Гадаад шилжих хөдөлгөөний тоон ба чанарын судалгаа 2016”-аас харахад, мөн л 20-34 насныхан дийлэнх хувийг эзэлж байна.

<sup>3</sup> Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний нөхцөл байдлын судалгааны тайлан, ХНХЯ, ХНХСИ, 2016

<sup>4</sup> Хүн ам, орон сууцны тооллого 2010, Завсрын тооллого 2015, Үндэсний статистикийн хороо, 2017

<sup>5</sup> Гадаад шилжих хөдөлгөөний тоон ба чанарын судалгааны тайлан, Хүний хөгжил судалгаа, сургалтын төв, 2017.

### Хүснэгт 6. Гадаадад оршин суугаа Монгол иргэдийн тоо, насны бүлэг, явсан зорилгоор, 2010

Насны бүлэг	Бүгд	Явсан зорилго					
		Суралцах	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Хувиараа ажиллах	Албан томилолтоор ажиллах	Эмчлүүлэх	Бусад
Бүгд	107 140	39 655	20 491	21 017	2 708	783	22 486
0-10	7 769	0	0	0	0	67	8 208
10-14	3 535	776	0	0	0	23	2 736
15-19	9 176	7 284	104	227	0	32	1 529
20-24	20 400	14 146	2 993	1 996	156	44	1 065
25-29	20 739	8 609	5 878	3 949	435	85	1 783
30-34	16 855	4 648	5 020	4 406	516	93	2 172
35-39	13 343	2 753	3 550	4 318	522	113	2 087
40-44	7 930	1 030	1 883	3 099	427	83	1 408
45-49	4 168	323	717	1 806	330	84	908
50-54	1 883	65	272	767	210	55	514
55-59	709	21	74	239	112	33	230
60-64	304	0	0	133	0	26	145
65-69	162	0	0	44	0	24	94
70+	167	0	0	33	0	28	106

Эх үүсвэр: ҮСХ 2011, "Хүн ам, орон сууцны тооллого 2010: Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэд", Сэдэвчилсэн судалгаа 13, Улаанбаатар хот.

Гадаадад оршин суугаа иргэдийн хүйсийн харьцаа 87.4 буюу 100 эмэгтэйд 87.4 эрэгтэй ногдож байна. Гэхдээ явсан улс орноор харвал, БНСУ, ОХУ-д байгаа монголчуудын дийлэнх эрэгтэйчүүд байхад АНУ, БНХАУ, БНЧУ, Япон улсад байгаа монгол иргэдийн дийлэнх нь эмэгтэйчүүд байна.

Гадаадад оршин суугаа иргэд хамгийн олноороо суурьшиж буй улс бол БНСУ байна. Гадаадад байгаа монголчуудын 27.6 хувь БНСУ-д, 15.9 хувь АНУ-д, 6.8 хувь БНЧУ, 6.8 хувь БНХАУ-д, 5.0 хувь Япон улсад, 4.7 хувь ОХУ-д тус тус ажиллаж, амьдарч байна.

Гадаадад ажиллаж амьдарч буй монголчуудын талаар хэд хэдэн удаагийн түүвэр судалгаа<sup>6</sup> хийгдсэн байдаг ч бүгд монголчууд хамгийн олноороо суурьшиж буй БНСУ, АНУ, Япон зэрэг улсад ажиллаж, амьдарч буй монголчуудыг хамруулсан байдаг тул бусад улс орнуудад ажиллаж, амьдарч буй монгол иргэдийн талаарх мэдээлэл ихээхэн хомс байна. Ийм учраас мэдээллийн олдоц, хүртээмжтэй байдлаас шалтгаалан БНСУ-д ажиллаж амьдарч буй монгол иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн

талаар энэхүү судалгааны ажилдаа авч үзлээ.

Монгол Улсын албан ёсны статистик мэдээллээр<sup>7</sup>, 2010 оны байдлаар БНСУ-д 29534 монгол иргэн ажиллаж, амьдарч байна гэсэн бол БНСУ-ын Хууль зүйн яамны мэдээллээр<sup>8</sup> 2010 оны байдлаар 24158 монгол иргэн хөдөлмөр эрхэлж байна гэжээ.

Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайдын яамны мэдээллээр<sup>9</sup>, 2012-2016 онд дунджаар 27732 монгол иргэн ажиллаж, амьдарч байна. БНСУ-д удаан хугацаагаар оршин сууж буй монгол иргэдийн тоо жил ирэх тутам нэмэгдсэн ч хөдөлмөр эрхлэх зорилгоор явсан иргэд, ялангуяа, гэрээт ажилчдын тоо жил бүр буурсан байдал ажиглагдаж байна (Хүснэгт 7). Монголчуудын БНСУ-д оршин суугаа зорилгыг авч үзвэл, таван хүн тутмын нэг нь хөдөлмөр эрхлэх зорилготой байна.

<sup>6</sup> Гадаад шилжих хөдөлгөөний тоон ба чанарын судалгаа, Хүний хөгжил судалгаа, сургалтын төв, 2017; Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний нөхцөл байдлын судалгаа, ХНХЯ, ХНХСИ, 2016; Гадаадад ажиллаж буй монгол иргэдийн нөхцөл байдал, үр дагавар судалгаа, Монголын хүн ам, хөгжил нийгэмлэг 2005.

<sup>7</sup> Хүн ам, орон сууцны тооллого 2010, Үндэсний статистикийн хороо, 2012

<sup>8</sup> ILO, 2011. International Migration Papers No.119

<sup>9</sup> Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний нөхцөл байдлын судалгаа, ХНХЯ, ХНХСИ, 2016



**Хүснэгт 7. БНСУ-д оршин суугаа Монгол иргэдийн тоо, зорилгоор, 2012-2016**

Он	Бүгд	Хууль ёсны оршин суугч			Хууль бус оршин суугч
		Хөдөлмөр эрхлэх	Суралцах	Бусад	
2012	26461	11047 (7581)	3033	3405	9619
2013	24175	9245 (8654)	2717	4466	8700
2014	24561	8805 (7839)	2518	5829	7409
2015	30527	8044 (7099)	2537	11671	8275
2016	32938	7125 (6980)	5814	10263	9736

Эх үүсвэр: Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайдын яамны мэдээллээс нэгтгэв.

Тайлбар: Хөдөлмөр эрхлэх зорилгоор оршин сууж буй нийт иргэдийн тооны ар талын хаалтанд байгаа тоо нь гэрээт ажилчдын тоог илэрхийлнэ.

Хөдөлмөр эрхэлж буй монгол иргэдийн дийлэнх олонх (92.8%) нь боловсруулах үйлдвэрлэл буюу аж үйлдвэрийн салбарт ажиллаж байна. Бусад нь барилга (1.5%), хөдөө аж ахуй (3.2%), үйлчилгээ (0.1%), загасны аж ахуй (1.6%)-д тус тус ажилладаг аж.

Хэдийгээр хөдөлмөр эрхэлж буй иргэдийн дийлэнх гэрээт ажиллагчид байгаа ч гэрээ зөрчигдөх, гэрээгээ зөрчих байдал ажил олгогч болоод ажиллагч хоёр талаас гардаг байна. Тухайлбал, БНСУ-ын Хөдөлмөрийн яамны мэдээллээс харахад<sup>9</sup>, ажил олгогч талаас гаргасан гэрээний зөрчлийн шалтгааныг авч үзвэл, талаас илүү хувь нь илүү цагийн хөлсийг олгоогүйгээс гэрээгээ цуцлах шаардлагатай болсон байна. Үүний дараагаар цалин (44.8%), ажлын цаг (37.9%), амралтын цаг (34.5%), өдрийн цагийн төлбөр (20.7%), байр сууц (17.2%), хоолны төлбөр (10.3%), ажлын байрны байршил (3.4%)-тай холбоотой шалтгаанууд орж байна. Харин монгол ажилчдын зүгээс гэрээ зөрчих байдал байдаг ч үүнийг албан ёсоор нотлох баримт мэдээлэл алга байна.

БНСУ-д хөдөлмөр эрхэлж буй иргэдийн дунд солонгос талын ажил олгогч болоод бусад ажилчдын зүгээс үзүүлдэг дарамт шахалт, хүчирхийлэл бүхий үйлдэлд өртөгсөд байна. Жишээлбэл, БНСУ-ын Хөдөлмөрийн яамнаас хийсэн судалгааны<sup>9</sup> дүнгээс харахад, гурван монгол ажилчин тутмын нэг нь ямар нэг байдлаар хэл амаар доромжлуулдаг байна. Мөн монгол ажилчдын дунд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа алдагдаж, осолд орох, ажил олгогч нь паспорт бичиг баримтыг хураан авах, ажлын нөхцөлөөс шалтгаалсан өвчлөлд нэрвэгдэх, илүү цагаар ажилласны хөлсийг олгохгүй байх зэрэг ажил олгогч

хуулийнхаа дагуу хүлээх үүрэг хариуцлагаа хүлээхгүй байгаатай холбоотой эрсдэлт байдал цөөнгүй тохиолддог байна.

БНСУ-д ажиллаж буй монгол иргэдийн талаар хийгдсэн судалгааны<sup>10</sup> дүнгээс харахад, 7 хоногт дунджаар 48.9 цаг ажилладаг байна. 2005 оны судалгааны дүнгээр, 7 хоногт 40 ба түүнээс дээш цаг ажилладаг гэж нийт судалгаанд оролцогчдын (N=379) 60 гаруй хувь хариулж байсан бол 2016 оны судалгааны үед нийт оролцогчдын (N=334) 80 гаруй хувь нь ийм хариултыг өгсөн байна.

БНСУ-д ажиллаж буй иргэдийн хөдөлмөрийн нөхцөлийг харвал, талаас илүү хувь нь “хэвийн”, гуравны нэг нь “хүнд”, 5 орчим хувь нь “хортой” нөхцөлд ажиллаж байгаа нь “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай хууль”-д Монгол хүнийг хортой нөхцөлд ажиллуулахыг хориглоно гэж заасан заалтыг зөрчиж байна.

БНСУ-д ажиллаж буй монгол иргэдийн цагт авдаг цалин хөлсний хэмжээг сонирхон үзвэл, нэг цагт 5-10 ам.долларын хөлс авах байдал хамгийн түгээмэл буюу судалгаанд оролцогчдын (N=334) 65 орчим хувь байна. Харин тавны нэг нь 10-15 ам.доллар цагт авдаг ажил эрхэлж байна. Энэхүү үндсэн цагийн хөлснөөс гадна нэмэлт цалин хөлс, урамшуулал авдаг эсэхийг сонирхоход, бараг тал хувь нь ямар нэг нэмэлт хөлс авдаггүй байна. Харин ажил олгогчийн зүгээс хоолоор хангах (76.3%), эрүүл мэндийн үзлэг эмчилгээнд хамруулах (25.4%), орон байраар хангах (18.6%), мөнгөн урамшуулал олгох (18.0), харилцаа холбоо (12.6%) болоод сургалтын дэмжлэг (12.0%) үзүүлэх зэрэг нэмэлт тусламж, үйлчилгээг үзүүлдэг байна. Эдгээр нэмэлт үйлчилгээ, тухайлбал, цалин хөлсний цагийн хэмжээ, илүү цагийн

<sup>10</sup> Гадаад шилжих хөдөлгөөний тоон ба чанарын судалгаа, Хүний хөгжил судалгаа, сургалтын төв, 2017; Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний нөхцөл байдлын судалгаа, ХНХЯ, ХНХСИ, 2016; Гадаадад ажиллаж буй монгол иргэдийн нөхцөл байдал, үр дагавар судалгаа, Монголын хүн ам, хөгжил нийгэмлэг 2005

хөлс, байр, хоолоор хангах, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах зэрэг нь хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан байдаг ч ажил олгогчийн зүгээс гэрээгээ зөрчих байдал цөөнгүй байдаг талаар дээр дурьдсан билээ.

Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй монгол иргэдийн хувьд заавал төлөх 4 төрлийн даатгал, хилээр гарах, батлан даалтын, нутаг буцах зардлын болон гэнэтийн ослын даатгал байдаг. Харин Монгол Улсынхаа нийгмийн даатгалд өөрийн хүсэлтээр сайн дураар даатгуулах боломжтой байдаг. Судалгаанд оролцогчдын 43.0 хувь нийгмийн даатгалд даатгуулсан байна. Харин даатгалд даатгуулаагүй иргэдийн талаас илүү нь “даатгуулах шаардлагагүй” гэж өөрсдөө үзсэн байна. Гэвч мэдээлэл дутмаг, үйлчилгээ авах боломжгүй байдал зэргээс болж үлдсэн хэсэг нь даатгалд хамрагдаж чадахгүй байгаа аж.

#### 4. ДҮГНЭЛТ

Монгол Улсын болоод Монгол Улс дах ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөний талаарх тоо мэдээлэл хомс, албан ёсоор бүртгэлжүүлэн, нэгтгэн, дүгнэх байдал дутагдалтай байна. Ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөний талаар, тухайлбал, Монгол Улсад ажиллаж буй нийт гадаад иргэд, Монгол Улсаас гадаадад ажиллаж амьдарч буй нийт монгол иргэдийн талаарх янз бүрийн эх үүсвэрийн, хэт ерөнхий тоо л байна. Иймд цаашид ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг албан ёсоор цуглуулдаг тогтолцоог бий болгох, ялангуяа, шилжилтийн зорилго, хөдөлмөрийн нөхцөл байдал, үр дагавар, бэрхшээл сорилтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулдаг, түүндээ дүн шинжилгээ хийж, бодлого боловсруулахад ашигладаг болох хэрэгтэй байна. Учир нь дэлхийн хүн ам зүйн шилжилтийн үр дагавраас шалтгаалсан насжих үйл явц улс орнуудыг хамарч, улмаар манай орны хувьд ч гэсэн хүн ам насжсанаар хөдөлмөрийн зах зээл ажиллах хүчний хомсдолд орж эхэлж байна. Хөдөлмөрийн зах зээлийн ажиллах хүчний хомсдолыг улс орнууд ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөнөөр зохицуулж байна. Иймд бид энэ талын тоо мэдээллийг албан ёсоор, дэлгэрэнгүй цуглуулахад анхаарах хэрэгтэй байна. Нөгөө талаар, гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч авахдаа тэдний эрх ашгийг хөндөж, хүний эрх, хөдөлмөрлөх

эрх зэрэгтэй холбоотой хууль эрхзүйн зөрчил гаргахгүй байхыг эрхэмлэх нь зүйтэй. Хууль эрхзүйн болоод хүний эрхийн зөрчил бий эсэхийг гагцхүү дэлгэрэнгүй цуглуулан, баримтжуулсан статистик мэдээллээр нотлох боломжтой байдаг тул нэн тэргүүнд гадаад шилжих хөдөлгөөний статистик мэдээллийн тогтолцоог сайжруулах хэрэгцээ шаардлага байна.

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

МХАХН, НҮБХАС, 2006. *Гадаадад ажиллаж буй монгол иргэдийн нөхцөл байдал, үр дагавар судалгааны тайлан*, Улаанбаатар

Монголын хууль эмэгтэйчүүдийн холбоо ТББ, 2015. *Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээний тайлан*, Улаанбаатар

ХНХЯ, ХНХСИ, 2016. *Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний нөхцөл байдлын судалгааны тайлан*, Улаанбаатар

ХНХЯ, НҮБХАС, ХХССТ, 2017. *Гадаад шилжих хөдөлгөөний тоон ба чанарын судалгааны тайлан*, Улаанбаатар

ХНХСИ, 2016. *Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийн нөхцөл байдлын судалгааны тайлан*, Улаанбаатар

ХНХСИ, 2016. *Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний өнөөгийн нөхцөл байдалд хийсэн баримт бичгийн шинжилгээний тайлан*, Улаанбаатар

ХНХСИ, 2016. *БНСУ, Япон улсад хөдөлмөр эрхэлж буй болон эх орондоо эргэн ирсэн иргэдийн нөхцөл байдлын судалгааны тайлан*, Улаанбаатар

ХХҮЕГ, 2010-2017. *Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал*, Улаанбаатар

ҮСХ, 2012. *Хүн ам, орон сууцны тооллого 2010: Гадаад оршин суугаа Монгол Улсын иргэд*, Улаанбаатар

ҮСХ, 2016. *Хүн ам, орон сууцны завсрын тооллого 2015*, Улаанбаатар

ILO, 2012. *International Migration Papers No.119*

UNs. 2018, Department of Economic and Social Affairs, *International Migration Policies Data Booklet*.